



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 406

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг
шинэчлэн тогтоож, балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн тусгай хамгаалалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 29,711,592.00 (хорин есөн сая долоон зуун арван нэгэн мянга таван зуун ерэн хоёр) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 6,000,000.00 (зургаан сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга Л.Алтангэрэл, "Засгийн газрын автобааз" төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлын үүрэг гүйцэтгэгч Г.Чинзориг, "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Цэдэвсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

137605813
21-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 03 дугаар сарын 08 өдрийн
126 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ, ҮНИЙГ
ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, "АЛТАЙ-УЛИАСТАЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИД БАЛАНСААС
БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шилжүүлэн авах байгууллага	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил
1	Хьюндай старекс, 1382 УНУ, арлын дугаар КМJWWH7WR7U760062	2006	29,711,592.00	"Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компани	6,000,000.00	2
	Нийт дүн		29,711,592.00 (хорин есөн сая долоон зуун арван нэгэн мянга таван зуун ерэн хоёр)		6,000,000.00 (зургаан сая)	